

 NATIONAL  
GEOGRAPHIC



МОНГОЛ УЛСЫН  
СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ  
ЖУУМЛААЛЫН ЯАМ

# TRAVELER

Nobody Knows This World Better

MAY/JUNE 2014

MONGOLIA

**ДОМОГ АМИЛАХ  
ЖИМ**

**15**

DESTINATIONS THAT  
DEFINE MONGOLIA

**НУУЦАС ДҮҮРЭН  
ШИШГЭД**

A JOURNEY ON THE  
REMOTE SHISHGED RIVER

**ОЛОН НИЙТИЙН  
СҮЛЖЭЭ**

THE SOCIAL NETWORK

**ИСТАНБУЛ  
ИРЭЭДҮЙН ХОТ**

ISTANBUL  
CITY OF THE FUTURE






# НУУЦАС ДҮҮРЭН ШИШГЭД

## A Journey on the Remote Shishged River

BY PATRICK PHILLIPS & V.BULGANBAYAR  
ПАТРИК ФИЛИПС | Б.БУЛГАНБАЯР





# ҮДЭЭС ХОЙШ ЗОГСОО ЗАЙГҮЙ СЭЛҮҮРДСЭЭР

хориод километр туулсны эцэст бид хоёр хийлдэг завиа чүүлгэж нэг эрэг дээр татан гаргалаа. Хойд зүгээс урссаар Шишгэдийн гол руу цутгах жижиг цутгалын бэлчир орчмоор загасчны отгуудын орой цухуйж харагдана. Бид хүрэх газраа ирсэн бололтой, төв суурингаас алслагдсан ёстой л онгон зэлүүд нутаг болох нь харваас андашгүй.

Эл хуль, буйдхан газарт биднийг угтсан дүрэмт хувцастай байгаль хамгаалагч “Өөрсдийн чинь аюулгүй байдлын үүднээс та нарыг цааш явуулахгүй” гэж хэлсэн нь сэтгэлийн хөөрлийг минь даруй унтрааж орхилоо.

Үлгэр домогт Шамбалын орон гэгдэж байсан Хөвсгөл хүний гар хүрээгүй онгон байгалийн гоо үзэсгэлэнгээрээ алдартай. Сибирийн элгэнд түрж орсон хилийн шугам бүхий энэ нутгийг Саяны Нурууны эгц өндөр уулс хойд талаас нь халхална. Намгархаг хотгор газар, балар битүү ойгоор хүрээлэгдсэн Дархадын Хотгор, нүүгэлтсэн их тайга Монголын сор болсон үзэсгэлэнтэй газруудын нэг байсаар эдүгээг хүрчээ. Үнэндээ энд зам гэхээр юм байхгүй боловч Орос, Монголын аль аль нь хилийн зурвас газартаа болж буй аливаа өөрчлөлтөд мэдрэг ханддаг.

Тиймээс ч байгаль хамгаалагч ийнхүү анхааруулсан байж мэднэ.

Шишгэд мөн загасаараа алдартай. Дархадын Хотгороор умар зүг мурилзан урсах энэ гол замдаа тайгын өргөн уудам нутгийн усыг хамж, Саяны нуруут дайран баруун зүг Оросын нутгийг чиглэнэ. Тэнд хойд мөсөн далайн ай савд багтах, уртаараа

After twenty kilometers of constant paddling that afternoon, we wearily pulled our inflatable kayak ashore. A small knot of empty fishing camps clustered around the confluence where a small tributary from the north spilled its waters into the much larger Shishged River. We were literally at the end of a road—here, pure, unadulterated wilderness pushed against the last fringe of civilization. A camouflage uniformed Park Ranger had greeted us from the shore as we kayaked toward this lonely outpost. “For your own safety,” he informed us, “I can’t allow you to go any further.” Not for no reason is the remote Shishged known for its mystery.

The Shishged is located in northern Mongolia’s Khovsgol province—once believed to be the mythical land of Shambala—a region famous today for its unspoiled natural beauty. The jagged Sayan Mountains guard the region to the north, where the border juts into the belly of Russian Siberia. Swampy depressions and tangled forests surround it elsewhere, ensuring that Khovsgol remains a part of independent Outer Mongolia to this day. The sparsely populated area

Зам ч үгүй, жим ч үгүй Их Жамс гол, түүнийг аялагчийн туршлага, адал явдалд дурлах чин хүсэлгүйгээр туулахад хэцүү (эсрэг тал). Амсхийх зуураа энэ зургийг авлаа (доод).

It would be difficult to pass Ikh Jams, the river with no road, no trail, without the experience of a traveller and a sincere ambition of an adventurer (opposite). This picture was captured while on a break (below).





дэлхийд тавдугаарт ордог Енисей мөрөнд цутгана. Задгай далайтай ийнхүү холбогддог нь хулдын овгийн хамгийн том загас болох уртаараа 1.5 метр хүрдэг тул загасны өлгий нутаг болгожээ. Гэхдээ бид хоёрын анхаарлыг энэ том загас бус харин голын түргэн урсгал, бартаа ихтэй боргио л татаж байсан юм. Монголын адал явдалт усан аяллын тухай “Mongol Extreme” хэмээх лавлахын ар талд мөрөн голуудын усны уналыг даруухан өнгөөр кодолсон график зураг бий. Энэ зурагнаас Шишгэд голыг төлөөлсөн зураас нь бусад голыг тэмдэглэсэн харьцангуй жижиг зураасуудын сүрийг мэдэгдэм дарахуйц бөгөөд Оросын хил рүү дөхөөд намжих хүртлээ бараг туждаа ширүүн урсгалтай болохыг харж болно. Уулын хариат урсгалаар хийлдэг болон каяак завьтай хөвөхөд тохиромжтой Монголын голуудыг танин мэдэж, туулж

is home to the ethnic Tuvan, known in Mongolia as the Tsaatan, or ‘reindeer people.’

The Shishged River drains a huge area of taiga, or boreal forest, as it meanders north through the Darkhad Depression before slicing due west through the SayanNuruu mountain range and into Russia. There it joins the arctic-bound Yenisei, the fifth longest river in the world. With a link to the open ocean, the Shishged is home to the incomparable Taimen, the largest species of salmon on the planet, which can reach lengths of over 60 inches.

But giant fish had not attracted us to this intriguing waterway; the allure had been the rapids. In the back pages of a Mongolian guidebook, ‘Mongol Extreme,’ there is a modest, color-coded graph displaying the outlines and gradients of Mongolia’s many rivers. We

had once marveled at the little colored line representing the Shishged, which noticeably eclipsed all the other colored lines on the page with its spine-tingling curves that increased in steepness all the way to the Russian border. As we were focused on exploring suitable Mongolian rivers for commercial whitewater rafting and kayaking opportunities, that was the place we most wanted to go.

Now, after several years of research and preparation, we were finally there. On that first morning in Khovsgol before we set off into the river, via radio-telephone from the village of Tsagaannuur, we confirmed our takeout plans with local Tsaatan friends. In 3 days we would meet a Tsaatan guide with pack animals, at the confluence where the Ikh Jams tributary joins the Shishged. This was 56 kilometers downstream from our starting point, where there was a rumored trail that led from the confluence back to civilization.

The first day on the Shishged was easy-going. We paddled in high spirits, until we spotted the stern-faced Park Ranger strolling down to the riverbank, curiously

inspecting our little inflatable kayak and its two occupants as we swiftly approached him on the current. Confirming his own suspicions, he hailed us from shore, waving his arm in the unmistakable international gesture that means, ‘Come over here, idiots.’

With all our papers in order, we were relatively certain we would be allowed to continue on our way after answering a few questions.

As we spoke to the Ranger, who was insistent we go no further, “I joked ‘And what if we just take off?’” says Bulgaa.

“We have boats with motors, and we will catch you,” the Ranger deadpanned.

But that broke the tension. We camped that night with our minder, and at some point during quiet conversation in flickering candlelight, the decision was made to allow us to continue on our journey.

We pushed the kayak into the river the next morning under sunny skies. Waving goodbye to our generous host, we gleefully left civilization behind, concentrating on the pristine, occasionally-whitewater wild as it stretched downstream in front of us. The river



үзэхээр аялалдаа гарсан бидний хувьд энэ гол хамгийн очуштай нь байлаа.

Олон жил судалж, бэлдсэний эцэст ийнхүү бид хүрээд ирлээ. Хөвсгөлд ирсэн эхний өглөө нь Цагааннуур сумын төвөөс радио холбоогоор цаатан найзуудтайгаа ярьж, замд гарах төлөвлөгөөгөө жин тан болгож авав. Гурав хоногийн дараа Шишгэд голд Их Жамс гол цутгадаг бэлчир дээр ачлагын цаагаа хөтлөн ирэх газарчинтай уулзахаар болсон юм.

Ширүүн царайтай байгаль хамгаалагч голын эрэг дагуу алхан ирэх зуураа бяцхан хийлдэг завьтай бид хоёрыг анхааралтай нь аргагүй, харц салгалгүй ажиглана. Биднийг сэжиглэж буй нь илт. Голын эрэг дээрээс хайнгадуухан гараа дохих нь “Солиотой амьтад минь, нааш ир” гэсэн маш ойлгомжтой утга бүхий интернационал дохио зангаа шиг санагдана.


Бидний бичиг баримт ном журмаараа болохоор цөөхөн юм асуугаад цааш аян замаа үргэлжлүүлэхийг зөвшөөрнө гэдэгт итгэлтэй байлаа. Бүр болохгүй бол зугтчихсан ч чадах юм чинь





Алтай Таван Богд, Тахилтын хөтөл рүү хөдлөхийн өмнө (эсрэг тал). Дэлхийн хэмжээнд устах аюулд орсон Умардын халиу /*Lutra lutra Linnaeus*/ -ны Монгол дахь сүүлчийн нутаг Шишгэд гол (дээд). Мөрөөдлийн гол Шишгэд "Бөөгийн шахаа". Багийн гишүүн Булганбаяр (доод).

Altai Tavan Bogd, before setting out for Takhilt gorge (opposite). Shishged river is the last Mongolian habitat of the globally endangered European Otter /*Lutra lutra Linnaeus*/ (above). Dream river Shishgit "Buugiin shahaa". Team member Bulganbayar (below).







Цагаан гол, Алтай Таван Богд (дээд). Нутгийн цаатан Баяндалай бидний ачааг хөлөглөж Мэнгэ Булагийн зуслангаас Цагааннуурын зүг хөдөллөө (доод).

Tsagaan river, Altai Tavan Bogd (above). Local reindeer herder Bayandalai carried our luggage from Menge Bulan camp to Tsagaannuur (below).





гэсэн адын бодол ч төрөөд амжлаа. Асуудлыг намжаах үүднээс “Хэрвээ бид хоёр зугтчихвал яана?” хэмээн тоглоом хийв.

“Манайх моторт завьтай, та нарыг барьж л орхино” хэмээн байгаль хамгаалагч гөлгөр чигээр хариуллаа. Гэхдээ хүйтэн харьцаа удсангүй. Байгаль хамгаалагчтай шөнийн турш яриа өрнүүлж, анивчих лааны гэрэлд аядуу ярилцах зуур биднийг аянаа цааш үргэлжлүүлэхийг тэрээр зөвшөөрсөн юм.

Өглөөний нартай уралдан бид хийлдэг завиа голд тавилаа. Өгөөмөр байцаагчтай гар даллан салах ёс хийгээд соёл иргэншлийг баяртайгаар ардаа орхиж, урсгал дагуу урдаас угтах ертөнцийг анхааралтай ажиглан аяллаа үргэлжлүүллээ. Голын өргөн 50-100 метрийн хооронд, төдий л гүн биш, тунгалаг усны түргэн урсгал нь 1 болон 2-р зэрэглэлд багтахаар. Мориор хүрч болох загасчны сүүлчийн хэдэн огтийг өнгөрснөөс хойш уулс гол руугаа шахуу болж ирсэн тул хамаг анхаарлаа ширүүн урсгалд хандуулахаас өөр аргагүй болов. Үд болохын алдад голын харгиа илтэд ширүүсч, 23 километр хөвсний эцэст завиа сэлүүрдсээр үдээс хойхно элстэй эрэгт гарч ирлээ. Тэгим хүйтэн голын усанд орж, үдийн хоолондоо нэмэр болгон хэдэн зэрлэг сонгино түүв. Шумууланд бариулснаас утаа бараадах нь зөв байсан тул гал хавиар эргэлдэж байсан бид хоёр хооллож аваад тус тусынхаа майханд амрахаар шургацгаалаа.

Маргааш өглөө нь цэлмэг хөх тэнгэрийн дор завиа усанд түрэх үед бид төлөвлөсөн хуваариасаа ялимгүй түрүүлж байсан юм. Эндээс цааш дахиад 13 километр хөвнө, энэ бол аяллын хамгийн ширүүн урсгалтай хэсэг. Тиймээс бид маш болгоомжтой явахаар шийдлээ. Голын урсгал айхтар ширүүн, нүдний өмнө эрчлэн эргэлдэж, эргээс эргийн хооронд ар нь үл харагдах булан тохойгоор хуйларсаар. Том том бул чулуутай, ширүүн урсгал нь энэ голыг 3-р зэрэглэлд багтана гэдгийг илтгэнэ. Урьдчилан тандсаны дараа л завьтай явах эсэхээ шийдэхүйц байлаа. Далбилзан боргилох их харгиан дунд гууглан уухайлсан бид голын цэнгэлд бүрнээ автжээ.

Урсгалд таарах өч төчнөөн саад бартааг сүлжиж, байнгын уран жолоодлогодоо сэтгэл хөөрсөн бид болзоот газартаа ирлээ. Энд ачлагын цаагаа хөтөлсөн газарчинтай уулзахаар болзсон. Их Жамс голын адаг дахь чулуурхаг эрэг дээр хийлдэг завиа татан гаргаж байхад хэтэрхий нам гүм байлаа. Үдээс хойш тэнгэрт шуурганы үүл хуралдан харанхуйлж, шиврээ борооны ачаар хорхой шавж шавахгүй нь сайхан. Чулуу ихтэй эргээр хөглөрөх нойтон модоор гал асаалаа. Саяхан л урсгалын чимээнээс даван, байгалийн аниргүйг цочоон хөөрүү гэгч нь уухайлж явсан бид дагшин байгалийн хэтэрхий нам гүм атлаа машид эзэрхий чимээнээс өөр ханыгүй орчинд сэтгэл түгшингүй сууна. Хоноглохоос өөр аргагүй нь тодорхой болоход “Цаадах чинь өнөө шөнө амжихгүй бол маргааш гарцаагүй ирнэ” хэмээн биесээ тайвшруулна. Маргааш нь үд болтол газарчинаа хүлээсэн ч тэр ирсэнгүй. Ингээд бид Их Жамс өгсөн явган алхахаар шийдлээ.

varied between 50-100 meters in width, and although it was not deep, the clear water was fast, producing mostly Class I and II river conditions. We passed a few final fish camps accessible by horse, and then the mountains shouldered in close about the river and our full attention was demanded by the fast moving water. The difficulty of the whitewater increased as the day wore on, and 23 kilometers later we paddled onto a welcoming sand beach in the late afternoon sunlight. We bathed in the icy river, and then gathered some wild onions for our pasta dinner. We hovered over the fire, preferring the smoke to being eaten alive by mosquitoes. After dinner we retreated to our respective shelters for the night.

We were slightly ahead of schedule when we pushed off the next morning under another clear blue sky. There were 13 kilometers of



river between us and our takeout point, but they were the steepest 13 kilometers of the trip, so we planned to proceed cautiously.

The river looked steeper, falling away in front of us and racing around blind corners with bank to bank currents and few places to stop. This section of the river was Class III, with one particular rapid worthy of first scouting ahead. We made a clean run, and whooped our way down the rolling waves, feeling as bold and spirited as the river.

Though we were distracted for much of the day by the constant maneuvering required to weave between the many obstacles in the river—an activity as fun as it was exhilarating—we approached our takeout rendezvous with ever-increasing trepidation. We arrived at the mouth of the Ikh James tributary and pulled the kayak up a rocky beach. The takeout point was painfully empty and quiet. The afternoon sky had darkened with storm clouds, and a gentle rain kept the bugs down long enough for us to light some damp wood scattered about the rocky beach. With a fire going, we retreated into the shifting smoke to keep the bugs at bay.

“If he wasn’t here by tonight,” we say as we turned in for sleep, “he said he’d definitely be here in the morning.”



Анхнаасаа аяллын төлөвлөгөөнд төвөг учирч болзошгүй гээд тээшээ аль болох хөнгөн байхаар бодож бэлтгэсэн нь зөв байжээ. Плитка байхгүй, хувцас цөөтэй. Тэгсэн атлаа л сэлүүр, каск, аврах хантааз, аяны хэрэгсэл нийлээд бараг л 25 килограмм татахаар. Түүний дээр үүргэвчний нимгэн зөөлөвчтэй нарийхан мөрөвч мөрөнд гүн шигдэж орсноос цусны эргэлт саатаж гар мэнчийж орхилоо. Хийлдэг завиа авч явах тухайд бодох ч хэрэггүй болохоор хожим олдохуйц тэмдэгтэй газар далдалж нуух зуураа дахин олж харах болов уу хэмээн битүүхэн санааширна.

Газрын байдал бага зэрэг өгсүүр, зам балархай болохоор байсхийгээд харгүй жимээ алдаж төөрнө. Зөөлхөн, намбаганасан хөрс, тээг болж унасан моддын дундуур алхана гэдэг өвдгөөр татсан гүн цасанд тамираа шавхан туучихтай адил ажээ. Саяхан явж өнгөрсөн баавгай, чонын шинэ мөр харгуйн шаварт гүн шигдэж үлдсэнийг анзаарахгүй байхын аргагүй. Амьтад бидний анх ирсэн зүг рүү чиглэсэн байгаа нь зам зуур л зөрж дээ гэмээр түгшүүрт бодол төрүүлнө. Тайгад зундаа шумуул хэцүү боловч бид шавьж үргээгч, толгойн тортой болохоор айхтар зовоосон нь үгүй. GPS, газрын зургаар бол бид ахиц муутайхан байгаа ч байгалийн үзэмж сайхан, цаг агаар тааламжтай байгаад талархмаар.

Тэнхээ мэдэн алхсан 8 цагт бид 16 километр зам хороов. Харанхуй болохын алдад цүнхээл устай цутгал бүхий хоноглоход тун тохирсон газарт хүрлээ. Чилсэн мөрөө амраахаар тээшээ мулталж унагаад, нэвт хөлөрсөн хүмүүс хувцастай чигээрээ цүнхээл рүү орж явчихав. Дагжиж гүйцсэн ч сэргээд ирсэн болохоор асаасан түүдэг галын илчинд ээн зогсоход, хувцасны ус дусалсаар байлаа.

Маргааш өглөө нь хоноглосон газраас хөдлөхтэй зэрэгцэн бороо асгаж эхэллээ. Шавар шавхай болсон харгуй дээр халтирч гулгаад явдал бүр ч удаан болов. Хоёр хоногийн дараа хүнс сэлбэнэ гэж тооцсон бидэнд хэлтэрхий шоколад, гурвалжин хайлмал бяслагнаас өөр гол зогоох зүйл үлдээгүй юм. Их Жамсад цутгах тоо томшгүй олон гол горхиор таслагдсан гуу хавцлаар өгсөж, уруудан гэлдрэх явцдаа хоол ундгүй тул ихэд ядарч байлаа. Орой болоход тэнгэр цэлмэж, харгуй тодорч, шумуулын довтолгоон саарсан тул бид хоёр хөндийгөөр арай хурдан алхаж байлаа.

Моддын оройгоор жаргах нарны сүүлчийн туяа тусаж, бидний сүүдэр үдшийн бүрэнхийд уусах хирд цаатнуудын отогт өдөртөө амжиж хүрэх найдвар тасрав. Өлсөж ядарсан, зориг мохсон бид харанхуй болохоос өмнө амжиж ундны устай хоноглох газар олж хүрэхээр яаравчлав. Гэтэл хэдхэн минутын дараа урцны бараа харагдаж хий юм үзэгдэв үү гэж өөрийн эрхгүй бодож билээ.

Ойролцоогоор 2 километрийн тэртээд айлсан буусан хориод цагаан урц, урцны оройгоос савсах утаа, идээшилж буй морьд харагдана. Цаг хугацааг ухраан хүн, байгаль хоёр эв зүйтэй зохицон амьдарч буй төгс дүр зураг бүхий 1880-аад оны үеийн Америкийн Их талд ороод ирчихлээ гэвэл шууд үнэмшихээр. Эхний урцанд дөхөж очиход агт морьд туурайгаараа газар цавчлах, хүүхдүүд инээлдэж, гадны хүний алхаанаас сэрэмжилсэн нохдын хуцах дуун сонсогдлоо. Бидний "Нохой хорь!" хэмээх ердийн монгол мэндчилгээг сонссон нүдэнд дулаахан залуу эр, царайлаг эхнэрийн хамт гэрэлтэй урцнаасаа гарч ирэхэд хөлд орж буй хүү нь эхийнхээ ард ичингүйрэн нуугдав. Удаж төдсөн ч үгүй

## АЯЛЛЫН ХАМГИЙН САЙХАН НЬ ЗОРЬСОН ГАЗРАА ХҮРЭХЭД БУС ХАРИН АЯЛЖ ЯВАА ҮЕ НЬ ЮМ БАЙНА ХЭМЭЭН БОДОГДОНО.

### WE RUMINATED ON THE JOURNEY, NOT AS A MEANS TO AN END, BUT AS A WORK IN PROGRESS.

We waited until noon the next day before starting our hike up the Ikh Jams. From the very beginning we had known that our takeout plans could go awry, so we had packed as light as possible. No stove; minimal clothing. Nonetheless, between paddles, helmets, lifejackets, and camping gear, my dry-bag weighed nearly 25 kilos. With the weight on our backs, the bag's two thin straps left deep indentations in our shoulders and caused our hands to bloat as the circulation was cut off. As for the kayak, carrying it out was out of the question. As we stashed it where we could find it later, we silently wondered whether we'd ever see it again...


The terrain was gently rolling, but the trail was indistinct and often precarious. Between the soft, spongy ground and the hurdles of fallen trees, the walking was akin to exhaustive post-holing through knee-deep snow. It was impossible not to notice the extremely fresh bear and wolf tracks deeply imprinted into the mud of the trail. Disturbingly, they were headed in the direction from which we had come, meaning we must have passed each other somewhere along the way. Mosquitoes are also notoriously bad in the taiga during summer, but we were prepared with bug repellent and headnets and thus did not suffer much. Our GPS and map confirmed our progress was slow, but at least the scenery was stunning and the weather favorable.

After 8 hours of strenuous walking, we had covered 16 kilometers. As darkness loomed we arrived at a perfect campsite perched above a pool in the river. We dropped our pack to the relief of our tender shoulders. Already soaked with sweat, I plunged into the creek completely clothed. Shivering but refreshed, I sloshed over to a fire that Bulgaa had blazing in a matter of minutes.

The rain began as we broke camp the next morning. The muddy conditions made the trail slippery and slowed our pace even more. By this time, two days after we had expected to resupply at the takeout, our food rations were down to bits of chocolate and small wedges of processed cheese. We nibbled on what remained for much needed calories, while staggering up and down ravines cut by the many tributary streams joining the Ikh Jams. As the day wore on and the weather cleared, the trail became more defined. The mosquito onslaught slackened and we made steady progress up the valley.

Our emergence above the tree line coincided nicely with dusk, and also with our admission that we would not reach the Tsaatan camp that day. Hungry, exhausted, and frustrated, we resolved to push on in the gathering dusk simply to reach the next side-stream for drinking water. When we spotted the Orts (Tuvan teepees) a few minutes later,





Хазарлагийн гол,  
Шишгэдийн цутгай  
адал явдалт аялалд яг  
тохирох газар. Хээрийн  
тоолны амт (эсрэг тал).  
Мөрөөдлийн гол Шишгэд

Khazarlag river and  
Shishged river are perfect  
for adventure. A meal on  
the wild shore. (opposite)

БАЙДАГ ХӨЛС ХҮЧЭЭ  
ШАВХСАН Ч ХАРИУ  
ШАГНАЛ НЬ АГУУ!

ALTHOUGH WE USED UP  
ALL OUR STRENGTH, THE  
REWARD WAS WORTH IT.





Суман гол адал явдалд дүрлэгсдйн  
очих ёстой газруудын нэг мөн.

Suman gol is a must-visit destination  
for all adventure seekers.

саяхан л ядарч зүдэрч явсан хоёр эр зуухны хажууд тухлан сууж, цааны өтгөн сүүтээр сүлсэн сайхан цай оочиж, боорцог амтархан идэнгээ гэрийн сониуч эздэд өөрсдийнхөө түүхийг ярьж өгөв. Шишгэд голд хийлдэг завиар хөвсөн бидний аялал энэ хүмүүст тийм ч сонин биш бололтой. Харин Их Жамс голын хөндийгөөс эдний отог хүртэл алхаж ирсэнд л хөөрцгөөх аж. Тэд бидэнд газарчин Баяндалай хөлөө гэмтээгээд очиж чадаагүй учрыг хэлж өглөө. Урцны дотор талыг сонирхон ажиглах аваас нутаг орчноосоо түүж цуглуулсан өвс ургамал, борц зэргийг баганаас өлгөсөн харагдана. Энэ бүхнийг харахад дэлхийн эдийн засгаас юутай алс тасран салснаа сая л нэг ойлгох шиг боллоо. Цаатнууд бүх хэрэглээгээ байгалиасаа олж авдаг нь гарцаагүй.

Маргааш өглөө нь буурал толгойтой Баяндалай цагаа ололгүй бэртсэндээ уучлал гуйн, дөрвөн сайхан цааны хамтаар хазганасаар хүрч ирлээ. Тэжээвэр цаа буганд бидний ачаа тээшийг ачиж 26 километрийн зайд байх Хармайн голын эхний хамгийн ойрын зам руу гаргаж өгөхөөр боллоо. Цаа гэдэг ухаалаг, хүнд ээлтэй, гайхалтай амьтан юм. Хүнд нүсэр ачаагүйдээ амар болж авсан бид замд хүрэх өгсүүр газрын ихэнхийг алхаж туулсан. Бартаа багатай газарт цааны нуруунд мордоод авна. Цаа буганы алхаагаар салаа туурай нь шажигнаж дуугарах аж. Шажиг, шажиг гээд л. Энэ жигдхэн дуу аяллын чимээ болон чихэнд хоногшин үлджээ. Уулнаа бидний тал бүрт сэтгэл түгшим цахилгаан цахилан, аянга бууж байснаас зам хүрэх халтиргаатай харгуйн ихэнхийг алхаж туулсан билээ. Бэртэнги хөлтэй

we thought for sure we were hallucinating.

They were about 2 kilometers in the distance, 20 or so elegant white teepees clustered in groups of two to five, complete with grazing horses and smoke drifting through the top openings. As we neared the first Orts we heard stomping hooves, children's laughter, and barking dogs alerted to two strangers approaching on foot. We called out the standard Mongolian greeting, "Hold the Dog!" A handsome young Tsaatan herder and his equally striking wife emerged from the glowing interior of the teepee, their toddler son bashfully hiding behind his mother's legs.

In no time we were inside their Orts, slurping delicious reindeer milk-tea and devouring homemade bread. Seated next to the warm stove, we related our story to our attentive hosts. Kayaking the Shishged River was of moderate interest to these people, but they were certainly impressed by our trek up the Ikh Jams River valley to their camp. We were informed that Bayandalai, Bulgaa's Tsaatan friend, had broken his leg, and therefore hadn't been able to make the rugged journey to meet us.

The next morning the grizzled Bayandalai limped over with four splendid reindeer to apologize for his untimely injury. He and the tamed caribou would transport us and our gear the 26 km to the nearest road. Reindeer are amazing animals; intelligent, friendly, and hard working. We walked the majority of the uphill terrain to the pass, a downright pleasant experience without our unwieldy loads. In less steep places, we climbed onto the backs of our respective reindeer



Баяндалай хамгийн урд тэргүүлэн, сонинд ороосон дүнсэн тамхиа хайнгадуухан сорно.

Оройн 7 цаг гэхэд бид зам дээр гарч ирлээ. Хармайн голын эхнээс Цагааннуур руу хүргэх унаанд сууж сумын төвд ирсэн бид хоёр диваажинд ирсэн амьтад аятай суурингаар хэсэж, гуанзны хоол, хүйтэн шар айраг эрээлэлгүй идэж уун, галладаг шүршүүрт орж аяны тоосноосоо салж авлаа. Маргааш нь тайгаас буцаж харих зам зууртаа өнгөрсөн жил мотоциклтой аялахдаа танил болсон газрууд өнгөрөхөд алсад манантах хуучин дурсамж толгой дотор эх захгүй хөвөрнө. Аяллын хамгийн сайхан нь зорьсон газраа хүрэхэд бус харин аялж яваа үе нь юм байна хэмээн бодогдоно.

Монгол бол өргөн уудам нутгийнхаа үзэсгэлэнгээр сул дорой хүнийг сөхрүүлж орхидог “өршөөлгүй багш” юм. Гэхдээ энэ уудам нутгийг зорин ирвэл харамсах зүйлгүй. Байдаг хөлс хүчээ шавхах хэрэг гарсан ч хариу шагнал нь агуу! Онгон байгальд хийсэн голын аялал маань таньж мэдэхгүй газарт эрэл хайгуулаар дүүрэн, адал явдалтай болж өндөрлөлөө. Өдгөө бидний амьдрах насанд оршин буй онгон байгалийн сайхан бүхнийг зэрвэс сонирхож, дэлхийд үлдэж хоцорсон чинхүү нүүдлийн соёлын нэгэн хэсэгтэй ийнхүү хальтхан танилцлаа.

and enjoyed the ride. Reindeer ankles click when they walk. Clickety-click, click, click. The sound came to be associated with smooth, easy travel. We walked much of the slippery trail down the pass, primarily because a worrisome electrical storm was sending lightning bolts exploding into the mountains on all sides of us. The injured Bayandalai rode at the front, nonchalantly smoking a cigarette hand-rolled in newspaper.

Around 7 pm we reached the road. After catching a ride back to Tsagaannuur, we staggered around the village like gluttons in an oasis of civilization, partaking shamelessly in cheap food, cold beer, and fire-heated showers. The next day, on the long drive back from the taiga, we passed through territory familiar from a motorcycle odyssey years earlier. We ruminated on the journey, not as a means to an end, but as a work in progress.

Mongolia is an unforgiving teacher, routinely testing feeble human ambitions with its vast, rough landscape. However, you also get back from the land what you put into it. For a few cups of blood, sweat, and tears, our rewards in return were great; unspoiled wilderness river travel; exploration and adventure in a wild environment; an encounter with one of the last true nomadic cultures on earth; each a brief glimpse into things that may very well cease to exist in our lifetime. ■


## THE INSIDER

Мөрөн хотоос цааш Улаан-Уул(180 км), Цагааннуур сум (100 км)-ын төвөөс цааш 10 км явж Шишгэдийн голын хөвдөг гүүр хүртэл 8-10 цаг явна. Хэрэв аяллын бүрэлдэхүүнд гадаадын иргэн байгаа бол хилийн бүсэд нэвтрэх зөвшөөрөл заавал авсан байх шаардлагатай. Зөвшөөрлийг Цагааннуур сумын төвд байх хилийн заставт бүртгүүлж, буцахдаа хасалт хийлгэнэ.

■ **АЛБАН ЁСНЫ АЯЛЛЫН КОМПАНИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ СОНИРХОЖ БАЙГАА БОЛ:**  
[WWW.MONGOLIARIVERADVENTURES.COM](http://WWW.MONGOLIARIVERADVENTURES.COM)  
[WWW.TOURMONGOLIA.COM](http://WWW.TOURMONGOLIA.COM)

You will have to drive from Murun city to Ulaan-Uul (180 km), from there; it will take another 8-10 hours to reach the Shishged river floating bridge, which is located 10 km from Tsagaannuur soum center (100 km). If your trip team includes foreigners, you will need to get a permit to enter the border area. To obtain a permit, you will need to register at the Border Patrol located at Tsagaannuur soum center, and deregister on your way back as well.

■ **FOR MORE INFORMATION ON THIS TRIP, VISIT THE OFFICIAL WEBSITES BELOW:**  
[WWW.MONGOLIARIVERADVENTURES.COM](http://WWW.MONGOLIARIVERADVENTURES.COM)  
[WWW.TOURMONGOLIA.COM](http://WWW.TOURMONGOLIA.COM)



Орхон голын бага хүрхрээ.

A small waterfall on the Orkhon River.

## PHOTO TIP

### ОНЦЛОХ ҮЗМЭРҮҮД:

- Мөрөн хот
- Улаан-Уул сум
- Хорьдол Сарьдагийн Нуруу
- Улаан тайгын нуруу
- Тэнгис, Шишгэдийн байгалийн цогцолборт газар
- Дархадын хотгор
- Шишгэд гол
- Тэнгис гол
- Их Жамс гол
- Хармайн гол
- Цагааннуур сум
- Цаатануудтай уулзаж, цаа буга унах
- Тайгын амьдрал, ахуй, үзэсгэлэнт зэрлэг байгаль

### THINGS TO SEE:

- Murun city
- Ulaan uul soum
- Khoridol Saridag mountains
- Ulaan taiga mountain range
- Tengis and Shishged National Park
- Darkhad valley
- Shishged river
- Tengis river
- Ikh Jams river
- Kharmain river
- Tsagaannuur soum
- Meet with reindeer herders and ride a reindeer
- The wild nature and beautiful life of the Taiga